



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/126

Хажуу шинэ-Ус

Хязгаарлалтын бүс тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 зүйлийн 29.1.3 дахь заалтын "А" хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 зүйлийн 17.2.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны 03 дугаар сарын 27-ны Говь-Угтаал сумын 3 дугаар багийн нутаг "Хүзүүвч" гэдэг газарт мал, амьтны халдварт Галзуу өвчин гарсантай холбогдуулан бүс нутгийн 3 хот айлын бэлчээр усыг харгалзан 14 хоногийн хязгаарлалтын бүс тогтоосугай.

2.Мал, амьтны халдварт Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг яаралтай зохион байгуулах, мал сүрэгт үзлэг хийж, халдваргүйжилтийн ажлыг чанартай зохион байгуулахыг Сумын малын эмч Д.Амгалан, Багийн засаг дарга Б.Даваасүрэн нар үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч А.Бямбадорж, Тархвар зүйч Б.Мягмарсүрэн нар даалгасугай.

ДАРГА



ТАРИУНАА

482401026